



**БУЛГАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/623

Булган сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, Тагнуулын байгууллагын тухай хуулийн 8¹ дүгээр зүйлийн 8¹.4, 24 дүгээр зүйлийн 24.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тагнуулын ерөнхий газрын Булган аймаг дахь хэлтсийн алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах нөхцөлөөр хангах зорилгоор Булган сум 6-р баг, С.Удвал-1-р гудамж 104 тоот хаягт байршилтай "Сайхан Уул" 3 апартмент төслийн байрнаас 2 өрөө 2 орон сууцны захиалгад шаардагдах 325,320,000 (Гурван зуун хорин таван сая гурван зуун хорин мянга) төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Төслийг хэрэгжүүлэгч "Хишигдулаан" ХХК-тай нийт 108,44 м.кв орон сууц захиалгаар бариулах гэрээ байгуулан гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

